



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 41 (566)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Газрын тосны бүтээгдэхүүний талаар авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2008 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны арваннэгдүгээр сарын 7 №41 (566)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

676. Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1154

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

677. Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 30 1154

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

678.	Роберт Е.Бедескийг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 304	1155
679.	Ким Ен Хүн-ийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай	Дугаар 305	1155
680.	Зарим хүнийг, одон медалиар шагнах тухай	Дугаар 306	1155
681.	Лувсангийн Одончимэдэд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 307	1157
682.	Гонгорын Лхагвасүрэнд Монгол улсын гавъяат багш цол хүртээх тухай	Дугаар 308	1157
683.	Дугарын Рэнчинхандад Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 309	1158
684.	Чойжгаваагийн Наранбаатарт Монгол Улсын гавъяат дасгалжуулагч цол хүртээх тухай	Дугаар 310	1158
685.	Дэмчигжавын Загдсүрэнд Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 311	1158
686.	Цогтын Бадамхатанд Монгол Улсын гавъяат дасгалжуулагч цол хүртээх тухай	Дугаар 312	1158
687.	Гаргилын Нэргүйд Монгол Улсын гавъяат агрономич цол хүртээх тухай	Дугаар 313	1159
688.	Нүүшигийн Шархүүд Монгол Улсын гавъяат агрономич цол хүртээх тухай	Дугаар 314	1159
689.	Дашдэлэгийн Болдод Монгол Улсын хөдөө аж ахуйн гавъяат механикжуулагч цол хүртээх тухай	Дугаар 315	1159
690.	Цэрэнгийн Дэмбэрэлд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай	Дугаар 316	1159
691.	Дониддагвын Ганбатад Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 317	1160
692.	Сумъяагийн Түмэнгэрэлд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 318	1160
693.	Цэндийн Отгонд Монгол Улсын гавъяат агрономич цол хүртээх тухай	Дугаар 319	1160
694.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 321	1160



Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

695. Газрын тосны бүтээгдэхүүний талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 08 1161

Тав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

696. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "... шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэж заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 08 1162

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 10 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 10.1.7 дахь заалт нэмсүгэй:

"10.1.7.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох албан татвар."

2 дугаар зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"10.3.1.Хувь хүний орлогын албан

татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар;"

3 дугаар зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2009 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 10 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Гаваагийн Батхүүг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж,

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүнээр баталсугай.

2. Энэ тогтоолыг 2008 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 304

Улаанбаатар хот

Роберт Е.Бедескийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, Канад Улсын харилцааг хөгжүүлэх болон монгол судлалд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Канадын Викториагийн их сургуулийн профессор Роберт Е.Бедескийг

"Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 305

Улаанбаатар хот

Ким Ен Хүн-ийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, БНСУ-ын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж БНСУ-ын Дэгү хотод суугаа Монгол Улсын

Өргөмжит консул Ким Ен Хүн-ийг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 306

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, спорт, хөдөө аж ахуй, газар тариалан, уул уурхай, эрчим хүч, цагдаа, төр захиргааны болон

төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Дашзэвэгийн Ганзориг - Биеийн тамир, спортын улсын хорооны шигшээ багийн дасгалжуулагч
2. Найдангийн Дашзэвэг - Төв аймгийн Жаргалант сумын багийн Засаг дарга, ахмад тариаланч
3. Буяндэлгэрийн Жавзандулам - Биеийн тамир, спортын улсын хорооны ахмад ажилтан
4. Дамдины Ламзав - Сэлэнгэ аймгийн газар тариалан үйлдвэрлэлийн "Азын хийморь" ББН-ийн эзэн, ахмад агрономич
5. Шаравын Мальдин - Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний "Амно корпораци" ХХК-ийн зөвлөх
6. Чулууны Насанбат - Биеийн тамир, спортын улсын хорооны спортын анагаах ухааны

- албаны ерөнхий эмч, боксын баг хариуцсан эмч
7. Галсанамрын Гүрээ-Очир - ШШГЕГ-ын харьяа "Сүлд" спорт хорооны дарга
 8. Доржийн Цогбаатар - Монголын олимпын боксын холбооны Ерөнхийлөгч, "Эрдэнэт" үйлдвэрийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газрын дарга
 9. Рэнцэндоржийн Цогтбаатар - Говь-Алтай аймгийн Засаг дарга
 10. Эрдэнэ-Очирын Энхбаяр - Биеийн тамир, спортын улсын хорооны массажист бага эмч
 11. Шаравжамцын Эрдэнэ-Очир - Булган аймгийн Биеийн тамир, спортын хорооны дасгалжуулагч

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Дамдингийн Баасанжав - Төв аймгийн Жаргалант сумын "Жинсрэгт Хайрхан" ХХК-ийн менежер
2. Хүүгийн Баянмонгол-Дархан-Уул аймгийн Гаалийн хорооны гаалийн улсын байцаагч

3. Даваажавын Баяраа - Булган аймгийн Орхон сумын "Орхон мандал" ХХК-ийн ерөнхий захирал
4. Намхайдоржийн Баярмаа - Улсын шигшээ багийн тамирчин
5. Галсандоржийн Баярсайхан-Өвөрхангай



аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эмэгтэйчүүдийн их эмч

6. Сандагийн Баясгалан - Монголын олимпын боксын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, олон улсын шүүгч

7. Бадамжавын Болдсайхан - Улсын Клиникийн төв эмнэлгийн уламжлалт эмчилгээний тасгийн их эмч

8. Шадавын Болормаа - Биеийн тамир спортын улсын хорооны анагаах ухааны албаны жудо, буудлагын баг хариуцсан их эмч

9. Бадралын Бурмаа - ХХААХҮЯ-ны газар тариалан, техник технологийн хэлтсийн дарга

10. Баасанхүүгийн Гансүх - БТСУХ-ны шигшээ багийн дасгалжуулагч

11. Дониддагвын Гантогтох - Нийслэлийн Баянгол дүүргийн 11 жилийн 13 дугаар сургуулийн газарзүйн багш

12. Дэмчигсүрэнгийн Ганчимэг - ЗГХЭГ-ын ахлах референт

13. Гаанжуурын Дулмаа - ЭНЭШТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн клиникийн зөвлөх эмч

14. Гомбын Дорж - Булган аймгийн Булган сумын иргэн, хувиараа ногоочин

15. Галсангийн Жигжидсүрэн - Баянхонгор аймгийн Хөдөө аж ахуйн газрын агрономич

16. Доржнямын Март - Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын газар тариалангийн "Чагтай" ХХК-ийн үтрэмийн эрхлэгч

17. Цэвэгсүрэнгийн Нандигжав - Монголын боксын холбооны шүүгчдийн зөвлөлийн дарга

18. Цэвэгжавын Насан - ШУА-ийн Палеонтологийн төвийн музейн ажилтан

19. Түмэнгийн Насанбаяр - Төв аймгийн Жаргалант сумын хөдөө аж ахуй, газар тариалангийн "Дэлгэр уянга" ХХК-ийн менежер

20. Дамбын Норджав - Нийслэл дэх хувийн хэвшлийн "Турван тамир" бүрэн дунд сургуулийн химийн багш

21. Данзангийн Нямжав - МУБИС-ийн орос хэлний тэнхимийн багш

22. Цагааны Одонбаяр - Биеийн тамир спортын улсын хорооны үндэсний шигшээ багийн ахлах мэргэжилтэн

23. Бадрайн Одонхүү - ХХААХҮЯ-ны Газар тариалан, техник технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

24. Амьбехийн Очир - Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын өндөр настан, ахмад тариаланч

25. Цэндийн Очирбал - Баянхонгор аймгийн Хөдөө аж ахуйн хоршоолгочдын холбооны дарга

26. Батын Санжааханд - Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь "Ургацын ундраа" ХХК-ийн гүйцэтгэх захирал

27. Цэдэнгийн Сүрэнжав - Орхон аймгийн "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн хяналтын инженер

28. Жанчивын Тамир - Улсын Клиникийн төв эмнэлгийн Сургалт, эрдэм шинжилгээний албаны дарга

29. Цоодолын Тогоодой - Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын иргэн, ахмад комбайнч, ногоочин

30. Шадавын Ухнаа - Сүхбаатар аймгийн өндөр настан, ахмад тариаланч

31. Очирбатын Цогзолмаа - Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн ээлжийн сувилагч

32. Далхаажавын Цэнгэлмаа - Нийслэлийн авто замын "Ай Си Ти сайн Консалтинг" ХХК-ийн ахлах инженер

33. Дэлэгийн Цэндсүрэн - Ховд аймгийн Жаргалант сумын газар тариалангийн "Үр жимс" хоршооны дарга

34. Лхамсүрэнгийн Цэрэнбумаа - Нийслэл дэх хувийн "Бумаа-санаа" эмнэлгийн шүдний их эмч

35. Лхамсүрэнгийн Цэрэндорж - ХХААХҮЯ-ны харьяа Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Өвөрхангай аймгийн Хархорин дахь салбарын захирал

36. Лочингийн Цэрэнсодном - МУБИС-ийн Дүрслэх урлаг, технологийн сургуулийн захирал

37. Лувсансодвын Чимэджамц - Нийслэлийн хувийн хэвшлийн "Турван тамир" бүрэн дунд сургуулийн математикийн багш

38. Жанцангийн Чимэддрэгзэн - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 11 жилийн 92 дугаар сургуулийн технологийн багш

39. Эрдэнэбаатарын Чойжил - Төв аймгийн Сүмбэр сумын газар тариалангийн "Өгөөж - Сүмбэр" ХК-ийн трактор-комбайнч

40. Санжаажамцын Чулуунаа - Нийслэл дэх "Петровис" ХХК-ийн ахлах менежер

41. Мягмарын Шинэчулуун - ХХААХҮЯ-ны харьяа Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Сэлэнгэ аймаг дахь салбарын ерөнхий инженер

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:

Дэлгэчоймболын Амарсайхан - О р х о н аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын

дарга, цагдаагийн хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Дашнямын Баасанжав - Сэлэнгэ аймгийн мал аж ахуй, газар тариалангийн "Орхон түшээ" ХХК-ийн захирал

ын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
3. Балчигийн Балжинням - Төв аймгийн Борнуур сумын ногоочин

2. Дангаагийн Байгалмаа - ЗМЯ-ны БТС-

4. Ренцэнхандын Баярсайхан - Дархан-



Уул аймгийн Хонгор сумын "Цайдам-Өгөөж" ХХК-ийн механикжуулагч

5. Раднаагийн Бумбага - Булган аймгийн Тэшиг сумын газар тариалангийн "Мөнх түрүү" ХХК-ийн захирал

6. Содын Бүрэнбат - Сэлэнгэ аймгийн Орхон сумын мал аж ахуй, газар тариалангийн "Орхон далай" ХХК-ийн захирал

7. Бадарчийн Золзаяа - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 12 дугаар цэцэрлэгийн багш

8. Жигжидсүрэнгийн Мөнхбат - Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн засварчин

9. Уранчимэгийн Мөнх-Эрдэнэ - Боксын шигшээ багийн тамирчин

10. Сүхээгийн Мягмар - Баянхонгор аймгийн Баянговь сумын хүн эмнэлгийн их эмч

11. Дамдинсүрэнгийн Нэргүй - Төв аймгийн Сүмбэр сумын газар тариалангийн "Өгөөж Сүмбэр"

ХК-ийн трактор-комбайнч

12. Юулайн Нямсүрэн - Булган аймгийн газар тариалангийн "Орхон-Мандал" ХХК-ийн тракторын жолооч

13. Дашравдангийн Цогтсайхан - Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын газар тариалангийн "Баян-Ундрага" ХХК-ийн трактор - комбайнч

14. Ачмаагийн Чулуун - Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын "Эхэндаваа" ХХК-ийн трактор-комбайнч

15. Бадарчийн Чулуунпүрэв - Биеийн тамир, спортын улсын хорооны Үндэсний шигшээ багуудын хүчний дасгалжуулагч

16. Жанчивын Эрдэнэбаатар - Төв аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын ерөнхий мал зүйч

17. Зоригтбаатарын Энхзориг - Боксын шигшээ багийн тамирчин

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Балсанлхүндэвийн Буянтөр - Эрүүгийн цагдаагийн газрын III хэлтсийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

2. Нямдаваагийн Жаргалсайхан - Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эдийн засгийн ахлах төлөөлөгч,

цагдаагийн хошууч

3. Шагдарын Оюунбаяр - Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын эдийн засгийн төлөөлөгч, цагдаагийн хошууч

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 307

Улаанбаатар хот

Лувсангийн Одончимэдэд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Төрийн байгууллагад олон жил, идэвхи санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, монгол орны өөрчлөлт, шинэчлэлттэй холбоотой хууль, эрхийн баримт бичгүүдийг боловсруулан батлуулах, парламентат ёсыг төлөвшүүлэн бэхжүүлэх, тэрчилэн хүүхдийн уран зохиол, шог хошин урлагийн төрлөөр олон арван бүтээл туурвиж,

Монголын соёлын түүхэн их өв Равжаа судлалыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж МУЗН-ийн ерөнхийлөгч Лувсангийн Одончимэдэд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 308

Улаанбаатар хот

Гонгорын Лхагвасүрэнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Боловсрол, биеийн тамир, спортын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлүүд туурвиж, спортын сургалт - дасгалжуулалтын онол арга зүйн үндэс болон сургалтын үндэсний технологи боловсруулж хэрэгжүүлэх, биеийн тамир, спортын мэргэжилтэй боловсон хүчин, өндөр зэрэг, цолтой тамирчид, дасгалжуулагчдыг сургаж бэлтгэхэд

орүүлсан хувь нэмрийг нь үнэлж Үндэсний биеийн тамирын дээд сургуулийн захирал, доктор, профессор Гонгорын Лхагвасүрэнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 309

Улаанбаатар хот

Дугарын Рэнчинхандад Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай

Уул уурхайн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, уул уурхайн үндэсний болон хамтарсан үйлдвэрүүдийг барьж байгуулах, удирдах, тэдгээрийн хүчин чадлыг бүрэн эзэмшиж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, үндэсний мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхэд

оруулсан хувь нэмрийг нь үнэлж Монгол-Оросын хамтарсан Эрдэнэт үйлдвэрийн зөвлөх Дугарын Рэнчинхандад Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 310

Улаанбаатар хот

Чойжгаваагийн Наранбаатар Монгол Улсын гавъяат дасгалжуулагч цол хүртээх тухай

Боловсрол, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, биеийн тамир, спортын салбарыг зөв менежментээр удирдан зохион байгуулж хөгжүүлэх, "Биеийн тамир, спортын тухай" хуулийг хэрэгжүүлэх, орчин үеийн спортын төрлийг өөрийн оронд сурталчилан дэлгэрүүлж, зуны олимпын ХХIX их наадамд Үндэсний шигшээ баг, тамирчдыг

амжилттай бэлтгэн оролцуулахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Чойжгаваагийн Наранбаатарт Монгол Улсын гавъяат дасгалжуулагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 311

Улаанбаатар хот

Дэмчигжавын Загдсүрэнд Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан цол хүртээх тухай

Эрүүл мэнд, биеийн тамир, спортын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, спортын анагаах ухааны чиглэлээр эрдэм шинжилгээний бүтээлүүд туурвиж, тамирчдыг шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэж сургах, биеийн тамир, спортын холбоодын материаллаг баазыг бэхжүүлэх, олимпын хөдөлгөөнийг өөрийн оронд дэлгэрүүлж, сурталчилахад оруулж байгаа

хувь нэмрийг нь үнэлж МҮОХ-ны ерөнхийлөгч Дэмчигжавын Загдсүрэнд Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 312

Улаанбаатар хот

Цогтын Бадамхатанд Монгол Улсын гавъяат дасгалжуулагч цол хүртээх тухай

Байт харвааны спортын дасгалжуулагчаар үр бүтээлтэй ажиллаж дасгалжуулсан баг, тамирчдаа олон улс, тив, дэлхий, олимпын наадмын тэмцээнүүдэд амжилттай оролцуулж, манай оронд байт харвааны спортыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Монгол

Улсын Үндэсний шигшээ багийн дасгалжуулагч Цогтын Бадамхатанд Монгол Улсын гавъяат дасгалжуулагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 313

Улаанбаатар
хот

Гаргилын Нэргүйд Монгол Улсын гавъяат агрономч цол хүртээх тухай

Хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, үр тарианы аж ахуйг мэргэжлийн өндөр түвшинд удирдан зохион байгуулж, шинэ техник, технологи нэвтрүүлэн газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улсын нөөцийг бүрдүүлэхэд оруулсан хувь

нэмрийг нь үнэлж Төв аймгийн Жаргалант сум дахь Улсын нөөцийн салбарын дарга Гаргилын Нэргүйд Монгол Улсын гавъяат агрономч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 314

Улаанбаатар
хот

Нүүшигийн Шархүүд Монгол Улсын гавъяат агрономч цол хүртээх тухай

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллан газар тариалангийн үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлж, жил бүр тогтвортой арвин ургац хураан улсын үрийн нөөц болон буудайн санд нийлүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр хангахад оруулж

байгаа хувь нэмрийг нь үнэлж Сэлэнгэ аймгийн Ерөө сумын "Их шинэстэй" ХХК-ийн агрономч Нүүшигийн Шархүүд Монгол Улсын гавъяат агрономч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 315

Улаанбаатар
хот

Дашдэлэгийн Болдод Монгол Улсын хөдөө аж ахуйн гавъяат механикжуулагч цол хүртээх тухай

Газар тариалангийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, техникийн засвар үйлчилгээг чанартай хийж, сааталгүй өндөр бүтээлтэй ажиллан га-гаас авах үр тарианы хэмжээг нэмэгдүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, залуу тариаланч, механикжуулагчдыг сургаж бэлтгэхэд

орүүлсан хувь нэмрийг нь үнэлж Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Шүрэн тариа" ХХК-ийн тракторч-комбайнч Дашдэлэгийн Болдод Монгол Улсын хөдөө аж ахуйн гавъяат механикжуулагч цол хүртээсүгэй

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 316

Улаанбаатар
хот

Цэрэнгийн Дэмбэрэлд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Дээд боловсролын салбарт санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, сургалт, эрдэм шинжилгээний ном, товхимол бичиж нийтлүүлэн, сургалтанд Кредит үнэлгээ, Ерөнхий шалгалтын тогтолцоог санаачлан нэвтрүүлж, "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-ыг боловсруулахад оруулсан хувь

нэмрийг нь үнэлж "Хан-Уул" дээд сургуулийн захирал, доктор, профессор Цэрэнгийн Дэмбэрэлд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 317

Улаанбаатар
хот

**Дониддагвын Ганбатад Монгол Улсын
аж үйлдвэрийн гавъяат ажилтан
цол хүртээх тухай**

Уул уурхайн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан, өөрийн оронд анхны Цайрын баяжуулах үйлдвэр байгуулж, үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлэн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, уул уурхайн үйлдвэрлэл, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж байгаа

хувь нэмрийг нь үнэлж "Цайртминерал" ХХК-ийн захирлуудын зөвлөлийн дэд дарга Дониддагвын Ганбатад Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 318

Улаанбаатар
хот

**Сумъяагийн Түмэнгэрэлд Монгол Улсын
аж үйлдвэрийн гавъяат ажилтан
цол хүртээх тухай**

Хүнсний үйлдвэрлэлийн салбарт үр бүтээлтэй ажиллаж, үйлдвэрийн техник, технологийг шинэчлэн бүтээгдэхүүний чанар үзэмжийг сайжруулж, шинэ бүтээгдэхүүн гаргах, хүн амыг хүнсний аюулгүй бүтээгдэхүүнээр хангах, ажлын байрыг нэмэгдүүлэхэд оруулж байгаа

хувь нэмрийг нь үнэлж "Өгөөж-4Цихэр боов" ХХК-ийн ерөнхий захирал Сумъяагийн Түмэнгэрэлд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 319

Улаанбаатар
хот

**Цэндийн Отгонд Монгол Улсын гавъяат
агрономч цол хүртээх тухай**

Хөдөө аж ахуйн салбарт он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, бүс нутагт тохирсон улаан буудайн сортуудыг нутагшуулан баруун бүс нутагт газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, мал сүргийг чанартай тэжээлээр хангах, залуу тариаланч механикжуулагчдыг сургаж бэлтгэхэд оруулсан

хувь нэмрийг нь үнэлж Увс аймгийн Тариалан сумын "Алтан дуулга" ХК-ийн ерөнхий агрономч Цэндийн Отгонд Монгол Улсын гавъяат агрономч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 10 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 321

Улаанбаатар
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,
томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

татсугай.
2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Литва Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Отгоны Дамбийнямыг томилсугай.

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Литва Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Тугалхүүгийн Баасансүрэнг эгүүлэн

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 10 дугаар сарын 08-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Газрын тосны бүтээгдэхүүний талаар авах зарим арга хэмжээний тухай

Онцгой албан татварын тухай хуулийн 6.7, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Импортоор оруулж байгаа автобензин, дизелийн түлшний гаалийн албан татварыг "5" хувиар, нэмэгдсэн өртгийн албан татварыг "10"

хувиар 2008 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн тус тус тогтоосугай.

2. Автобензин, дизелийн түлшийг импортоор оруулж байгаа хилийн боомтоос хамааруулан дараахь хэмжээгээр 2008 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн онцгой албан татвар ногдуулсугай:

№	Хилийн боомтын нэр	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ (ам. долларт шилжүүлснээр)		
		Автобензин (шинжилгээний аргаар тодорхойлсон октаны хэмжээ)		Дизелийн түлш
		90 хүртэл	90 ба түүнээс дээш	
1	Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Тэс, Бургастай, Гашуунсухайт	11.00	12.00	15.00
2	Ханх, Ульханмайхан	17.00	21.00	19.00
3	Сүхбаатар, Замын-Үүд, Эрэнцав, Алтанбулаг	38.00	43.00	48.00

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2008 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 282 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийг 2008 оны 10 дугаар

сарын 15-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2008 оны 10 дугаар сарын 29-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэж заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.45 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Цэцийн дарга Д.Бямбадорж даргалж, гишүүн Н.Жанцан, Д.Наранчимэг, Ц.Сарантуяа/илтгэгч/, Д.Мөнхгэрэл нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар С.Эхнтуулыг оролцуулан Цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Цэцийн хуралдаанд өргөдөл гаргагч Нийслэлийн Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Манлайбаатар, Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Цэнд-Аюуш, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтын "...шүүхийн шийдвэрийг давж заалдах... эрхтэй..." гэснийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Манлайбаатар, Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Цэнд-Аюуш нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 09-ний өдөр "Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийг батлан гаргасан. Энэ хуулиар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 48 дугаар бүлэг/хуулийн 414 дүгээр зүйлээс 419 дүгээр зүйл хүртэл/-т Эрүүгийн хэргийн хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаагэсэн шинэзлэг зохицуулалт нэмэлтээр оруулсан. Ингэхдээ эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт давж заалдах болон хяналтын шатны журмаар гомдол гаргахгүй байхаар хуульчилжээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтыг зөрчиж байна. Тодруулбал:

...Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2-т

"Шүүгч хэргийг хүлээн авсанаас хойш 72 цагийн дотор шүүгдэгч, хохирогч, өмгөөлөгч, прокурорыг байлцуулан хэргийг шийдвэрлэн тогтоол гаргах ба шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэж заажээ.

2007 оны 8 дугаар сарын 09-нд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилттэй холбогдуулан Улсын Дээд Шүүхээс уг хуулийг хэрэглэх журмын тухай 2007 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн №35 тоот тогтоолыг гаргасан. Уг тогтоолын 17-д "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2-т заасан "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй гэдгийг хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шийтгэх болон цагаатгах тогтоолд давж заалдах гомдол гаргахгүй гэж ойлгоно" гэж тайлбарлажээ.

... Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 307 дугаар зүйлд шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжинд гомдол, эсэргүүцэл бичиж болохгүй тохиолдлуудыг хуульчилсан байдаг. Эдгээр нь таслан сэргийлэх арга хэмжээ авах, түүнийг өөрчлөх, хэргийн харъяалал тогтоох, шүүхээс шүүх хуралдааны дэгийг зөрчсөнд хариуцлага хүлээлгэх, хэргийг түдгэлзүүлэх зэрэг асуудлаар гаргасан шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжид гомдол эсэргүүцэл бичиж болохгүй тохиолдлууд байдаг. Энэ нь Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн явдал биш бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилтыг хангахад чиглэгддэг.

Харин эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шүүхээр шийдвэрлээд гаргасан шүүхийн шийтгэх тогтоол болон цагаатгах тогтоолд гомдол, эсэргүүцэл, бичиж болохгүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтыг ноцтой зөрчсөн явдал мөн. ..." гэжээ.

Хоёр. Улсын Их Хурлын даргын 2008 оны 10 дүгээр сарын 13-ны өдрийн 107 дугаар захирамжаар томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"...Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь энэ хуулийн 414 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд, гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, хохирогч нар



харилцан зөвшөөрсөн, хүсэлт гаргасан, хохирогч хохирлын талаар маргаангүй байх эдгээр гол нөхцөл бүрдсэн тохиолдолд явагдана. Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэхээс татгалзсан, нэмэлт ажиллагаа хийлгэх хүсэлт гаргасан, хохирлын хэмжээ болон ногдуулах ялын талаар маргаантай бол хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдахгүй ба хэргийг ердийн журмаар шийдвэрлэнэ. Үүнийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 415, 416 дугаар зүйл болон 417 дугаар зүйлийн 417.4-д "Сэжигтэн, яллагдагч, хохирогч нэмэлт ажиллагаа хийлгэх хүсэлт гаргасан, эсхүл хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэхээс татгалзсан, хохирогч ялын талаар санал зөрсөн бол хэргийг ердийн журмаар шийдвэрлэхээр прокурор тогтоол гаргана.", 418 дугаар зүйлийн 418.6-д "Хэрэг хянан шийдвэрлэх явцад яллагдагч, хохирогч нэмэлт ажиллагаа хийлгэх хүсэлт гаргасан бол хэргийг ердийн журмаар шийдвэрлэхээр шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана" гэж тодорхой заасан байна. Эндээс үзэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд яллагдагч, хохирогч хүсэлтээ гаргаж хэргийг ердийн журмаар шийдвэрлүүлэх эрхтэй байна. Шүүх хуульд заасан шаардлага хангагдсан нөхцөлд хэргийг хянан шийдвэрлэх товгыг зарлаж, шүүгдэгч, хохирогч, өмгөөлөгч, прокурорыг байлцуулан хэргийг шийдвэрлэж байгаа болно. Нэгэнт өөрсдийн хүсэлтээрээ хэрэгээ шийдвэрлүүлж байгаа тул давж заалдах эрх зөрчигдсөн гэж үзэх үндэслэлгүй юм. Оролдогч нараас эргэлзээ төрвөл хэргийг ердийн журмаар шийдвэрлүүлэн гарсан шийдвэрт нь хуулийн дагуу давж заалдах бүрэн эрх нь нээлттэй байгаа болно.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсгийн "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэсэн заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "...шүүхийн шийдвэрийг давж заалдах" гэсэн хэсгийг зөрчсөн гэх үндэслэлгүй байна." гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэж заасан нь хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шийтгэх болон цагаатгах тогтоолд давж заалдах гомдол гаргахгүй гэсэн агуулгыг илэрхийлж байна.
2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэж зааснаар эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийтгэх болон цагаатгах тогтоолд гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх боломжийг шүүгдэгч, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгчдийн хувьд хааж, эрүүгийн

байцаан шийтгэх ажиллагааны явцад, ялангуяа шүүхийн шатанд процессын журам зөрчигдсэн, эсхүл эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, шүүхээс оногдуулсан ялтай санал нийлээгүй тохиолдолд Үндсэн хууль болон бусад хуулиар баталгаажуулсан эрхээ хамгаалуулах, сэргээн тогтоолгохоор шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй байхаар хуульчилсан байна.

Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон улсын пактад ямар нэг гэмт зэрэгт шийтгүүлж ял заагдсан хүн бүр шийтгэгдсэнээ болон оногдсон ялыг эргэж хянуулахаар хуулийн дагуу дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй болохыг заасан байна.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтын "...шүүхийн шийдвэрийг давж заалдах... эрхтэй..." гэснийг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтын "...шүүхийн шийдвэрийг давж заалдах... эрхтэй..." гэснийг зөрчсөн байна.
2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсгийн "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэсэн хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн 2008 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.
3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногт багтаан хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ
ГИШҮҮД**

**Ж.БЯМБАДОРЖ
Н.ЖАНЦАН
Д.НАРАНЧИМЭГ
Ц.САРАНТУЯА
Д.МӨНХГЭРЭЛ**



УНШИГЧДЫН АНХААРЛАД

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2008 оны 26 дугаарт нийтлэгдсэн Засгийн газрын 2008 оны 92 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг дор дурдсанаар залруулан уншина уу.
Засгийн газрын хэрэг эрхлэх газар

"ХҮҮХЭД БҮРТ КОМПЬЮТЕР" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Дүн (төг)
1	Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны төсөв (цалин урамшуулал)	7 хүн	83,240,000.0
2	Гаалийн бүрдүүлэлт хийх, дотоодод тээвэрлэх, агуулах түрээслэх зардал	19000 компьютер	12,540,000.0
3	Орон нутагт компьютер хүргэх зардал	19000 компьютер	20,995,000.0
4	Сургалтын программ суулгах зардал (1 компьютерт 1000төг)	20000 компьютер	20,000,000.0
5	Улсын төсвөөс худалдан авах компьютерийн зардал	3193 компьютер	703,568,865.0
6	Нэмэлт тоног төхөөрөмж	19000 компьютер	179,480,000.0
7	Сургалт	1800 хүн	100,000,000.0
8	Монгол агуулгыг хөгжүүлэх	303 агуулга	593,765,596.0
9	Сургалтын материалыг бэлтгэх (6 гарын авлага болон орчуулгын программ)	20000 компьютер	844,000,000.0
10	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын зардал	300 хүн	133,310,000.0
11	Жил бүрийн урсгал зардал	80 сургууль	124,080,000.0
	Дүн		2,814,979,461.0

Тайлбар: 1 ам.долларын ханшийг Монгол банкны 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн ханшаар тооцсон болно.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 1.5